



АРДЫН СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН ТОГТВОРТОЙ ХЭЛЛЭГЭЭР ИЛРЭХ НЬ

(Ямааны бэлчээрт нөлөөлөлтийн жишээгээр)

Д.Мөнхтамир¹, С.Бямбадорж¹

¹ Антропологи, Археологийн тэнхим, МУИС, Монгол улс
Цахим шуудан: s.tamiraa11@gmail.com

Редакцид ирүүлсэн: 2017.03.08

ОРШИЛ

Монголчууд өөрсдийн оршин буй байгаль, цаг уурын нөхцөлд тохируулан нүүдлийн мал аж ахуй (НМАА) эрхэлж аж төрдөг ард түмэн бөгөөд энэ нь тэдний амь ахуй, зан заншил, соёл, сэтгэлгээ зэрэгт гүнээ шингэсэн байдаг. Улмаар энэ байдал нь тухайн ард түмний хэлээр нь дамжин гарах үзэгдлийг хэл шинжлэл, угсаатны зүй, сэтгэл судлал зэргийн ухаан судлан шинжлэх бөгөөд энэхүү ажлаар уг үзэгдлийн өчүүхэн хэсгийг тайлбарлахыг зорьсон болно. Монголчуудын уламжлалт

нүүдлийн соёлыг судлахад Байгаль-Хүн-Мал гурвын харилцаа холбоог судлах нь хамгийн чухал юм. Гэтэл сүүлийн жилд бэлчээрийн доройтол Монгол оронд ихээхэн явагдаж, НМАА-н оршин тогтнох амин сүнс бэлчээрт аюул тулгарч байна. Үүнд олон хүчин зүйлс нөлөөлж буй боловч энэ удаад мал сүргийн зохистой бүтцийг хөндөж, түүнийг Монголчууд ардын уламжлалт ухаанаар хэрхэн хойч үедээ өвлүүлж байсныг ардын билиг зүй, тэр дундаа тогтвортой хэллэгээр тайлбарласан болно.

Түлхүүр үгс: Ардын сурган хүмүүжүүлэх ухаан, тогтвортой хэллэг, ардын билиг зүй, нүүдлийн мал аж ахуй, бэлчээр, ямаа

ТОГТВОРТОЙ ХЭЛЛЭГИЙН ТУХАЙД

Ардын билиг зүй гэдэг нь аливаа ард түмний бүтээсэн соёлын үнэлэмж, илэрхийлэл бөгөөд харин өвөрмөц хэлц

нь тогтвортой хэллэгүүд доторх нэг бүрэлдэхүүн нь юм. Үүнийг зураглавал:

ардын билиг зүй (фольклор) → тогтвортой хэллэг → өвөрмөц хэлц

Өвөрмөц хэлц нь аливаа үндэстний хэлний хөгжлийн явцад боловсрон бий болж, хэвшин тогтдог, тухайн ард түмний

аж амьдрал, ахуй орчин, зан заншил, соёл, сэтгэлгээний онцлогийг тусгадаг бэхжмэл цул бүтэц¹ юм. Уг өвөрмөц хэлц нь үүсэхдээ

1. Бат-Ирээдүй. Ж., 2009. Монгол хэл бичиг утга, соёл, хэрэглээ, УБ., 38



аливаа ард түмэн шинэ зүйлийг нэрлэхдээ урьдын мэдлэг, хэлэн дэх хэрэглэгдэхүүн дээрээ үндэслэн түүний шинж чанар зэргээр нь хийсвэрлэж зүйрлэдэг. Уг шууд бус нэрлэлт нь хэлээр илрэх аливаа ард түмний сэтгэлгээний онцлог, танин мэдэхүй, хувьсал хөгжил зэргийн илрэл болдог.

Аливаа соёл-хэлт үндэстний эртнээс нааш аж төрж ирсэн нутаг орон, эрхлэх аж ахуй, зан заншил, шашин шүтлэг зэргийн өвөрмөц онцлогоос үүдэн тухайн үзэгдэл, үйл явц, нөхцөл байдал, шинж чанар зэргийн үнэлэх үнэлэмжийн жишиг хэмжүүр (эталон) бий болдог. Эдгээр эталон нь тухайн ард түмний сэтгэлгээний хэв шинжийг тодорхойлох гэрч² болдог байна. Уг сэтгэлгээний хэв шинж, өвөрмөц онцлог тусдаг хэлний баримт болох этгээд үг хэллэг, зүйр цэцэн үг, өвөрмөц хэлц, ертөнцийн гурав, түргэн хэллэг зэрэг тогтвортой хэллэгүүд нь хүн судлал, угсаатны зүй, угсаа-сэтгэц хэл шинжлэлийн салбарын чухал судлагдахуун³ болдог.

Тэгвэл Монгол хэлний хэлц нэгжийг М.Базаррагчаа бүтэц, утга, хэлбэрийн талаас; Д.Бадамдорж, Ж.Баянсан, Б.Пүрэв-Очир, Б.Баттогтох нар голдуу утга, хэрэглээ, орны талаас; Г.Аким, Бүрэнтөгс, Л.Дашням, Ж.Бат-Ирээдүй нар толилох, зүйлчлэх, ангилах талаас нь тус тус илүүтэй судалсан байдаг бол үүнийг үндэстний соёлын сэтгэлгээ, сурган хүмүүжил талаас нь судалсан байдал тун хомс⁴ ажээ.

Энэхүү өгүүлэлд Монголчуудын соёл, сэтгэлгээний өвөрмөц онцлогийг хэлэн дэх тогтвортой хэллэг, түүний жишиг хэмжүүрийг ямаагаар жишээлүүлэн гаргахыг хичээлээ. Мезолитийн үеэс одоогийн 5 хошуу малын өвгүүдийг

гаршуулж эхэлсэн⁵ бөгөөд ямааг Ойрхи дорнодод янгирын бүлгэмдэл болох *Capra aegagrus*-аас гаргаж авсан⁶ байна. Харин Монголын зарим эрдэмтэд Монгол янгир болон ямааны эврийн бүтцийг үндэслэн 6-7 мянган жилийн өмнө Төв Азид *Capra aegagrus* (Иран, дундад Ази орчмоор тархмал), *C. falconeri* (Пакистанаар тархмал), *C. prisca* (Европт сөнөсөн) гэсэн гурван зүйл янгирын нэгээс ямааг гаршуулж⁷, улмаар Европ болон бусад зүгт тархсан⁸ гэж үздэг. Үүнээс үзэхэд Монголчууд ямаа гэдэг амьтантай танилцаад, уг амьтныг гаршуулж, гэжээгээд наад зах нь 6000 гаруй жил болж буй тул тэдний хэл, сэтгэхүйд уг амьтан ямарваа байдлаар тусах нь зүйн хэрэг бөгөөд харин өнөөгийн нөхцөл байдалд (тэр дундаа одоогийн байдлаар мал сүргийн тал орчим хувийг дангаараа эзлэх болсон) чухам ямар байдлаар тусж буй нь ихээхэн сонирхолтой юм.

Аливаа зүйл тухайн соёлд хэзээд эерэг, сөрөг хоёр талаар тайлбарлагддаг бөгөөд хоёр талтай байдгийн үлгэрээр ямаа гэгч амьтан Монголчуудын хэл, сэтгэлгээнд эерэг, сөрөг хоёр байдлаар илэрдэг. Энэ нь түүний зан авир, ашиг шим, үр нөлөө зэргээс хамаарч байгаа бөгөөд уг тохиолдолд түүнийг ихэвчлэн сөрөг байдлаар тайлбарлаж буйн нэгэн шалтгааныг гаргахыг зорьсон болно. Харин Монгол хэлэнд буй ямаа болоод түүний хамааралтай төрөл нэр жишиг хэмжүүр нь болсон тогтвортой хэллэгүүдийг шүүн үзээд заримыг нь төлөөлүүлэн үзэхэд:

ямаан омог: сүржин, огцом түргэн ууртай зан⁹- Ямаа болбоос ихээхэн сэргэлэн, шалмаг зантай бөгөөд хонийг бодвол соргог, түргэн хөдөлгөөнтэйн дээр

2. Баянсан.Ж., 2002. Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ., УБ, 1-3

3. Монгол хэлбичиг утга, соёл, хэрэглээ, дурд.зохиол, 47

4. Мөн тэнд, 41

5. Биологийн ангиллын хувьд *Capra aegagrus hircus*

6. Монгол малын шинжийн судар, дурд.зохиол, 34

7. Батаа. Д, (нар), Бэлчээрийн Монгол мал үржүүлэх арга ухаан, УБ., 2011, 361

8. Умард Африкийн нүүдлийн мал аж ахуй, дурд.зохиол, 18

9. Аким. Г., 1982. Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь, УБ., 187

түүнийг дагаад зан авир нь ч тогтворгүй, хувирант ихтэй байдгийг харуулсан.

яргуй хөөсөн ямаа шиг (хэлц үг)- ямар нэг сайхан юмны араас шунан хөөцөлдөх, туушгүйгээр дагах- Дээр хэлсэнчлэн ямаа нь шалмаг, соргог зан авиртайн дээр өвсний сорыг түүж идэхийн тулд нэг газраа удаан идээшилдэггүй, идээшилж буй газраа солиж шимтэй ногоо эрэн хайж явдаг байдлыг харуулсан.

ямаанаас янзтай, тэмээнээс гэдгэр: этгээд гажууд, сонин хачин ааш авиртай- Ямааны тогтворгүй, хувирамтгай зан авиртай холбоотой ба түүнийг ямаанаас янзтай гэж, харин тэмээ угаас алсыг харж, гэдийж явдаг бөгөөд малын ийм хачин, онцлогтой зан авирыг хүнтэй холбож үзсэн хэрэг юм.

ямаа гэхээр тэмээ гэх/тэмээ гэхээр ямаа гэх: тэнэг, зөрүүд- Дээр дурдсанчлан тэс өөр хоёр зан авиртай амьтдыг харьцуулж байгаа нь тэс өөр юм ярих буюу тэнэгтэх, зөрүүдлэх утгыг гаргасан байна.

зуун ямаанд жаран ухна: юмыг тэнцвэргүй болгох, тоог нь ихдүүлэх, бага зүйлд их ажил болгох- Судлаачдын тооцоолсноор энгийн хээлтүүлгийн үед нэг ухнад 50-90 орчим эм ямаа оногддог¹⁰ байна. Нэг ухны хийж болох ажилд жаран ухна тавьж буй, мөн хуц бус ухнаар төлөөлүүлж буй нь Монголчууд ухнаар тэнэг, сөрөг байдлыг илэрхийлдэгтэй холбоото й юм.

ишгэн шийр ч үгүй (хэлц)- юу ч үгүй, ядуу хоосон гэсэн санаа- Таван хошуу малын дотроос биеэр ямаа хамгийн жижиг нь байхад түүний төл ямар байх нь ойлгомжтой. Ишигний шийр гэдэг бол нэгдүгээрт хамгийн жижиг, хоёрдугаарт Монголчууд бараг хэрэглэдэггүй идэш тул ийм зүйл ч үгүй байна гэдэг бол хоосон, ядуу гэсэн санааг шууд илэрхийлнэ.

өнчин ишиг ч дутаахгүй (хэлц үг) -

ганц мал ч дутаахгүй, хумсын чинээ юм ч хороохгүй гэсэн санаа- Дээрхтэй адил ишиг гэдэг таван хошуу малын хамгийн бага, дорой, үнэлэмж бага амьтан тул түүнийг ч дутаахгүй гэдэг нь юу ч дутаахгүй гэсэн санаа юм.

ишиг эгээ л хаячихсангүй - хөлдөх шахах, маш их даарах¹¹- Ямаа тарга авахдаа дотуур-бөөр, сэмжээрээ өөхөлдөг тул гадуур өөхөлдөггүй бөгөөд таван хошуу малын дотроос хамгийн бээрэг нь болдог. Харин хээлтэй ямаа сэрүүний улиралд даарч, хөрөхөөрөө хээл хаях нь амар болдог бөгөөд үүнийг илтгэсэн ажээ.

ямааны мах халуун дээрээ: аливаа хэрэг явдлыг шинэ сэргэг дээр нь- Ямааны мах, өөхний бүтэц хонь зэргийнхээс өөр байдаг тул хүйтэн чанарын махтай амьтан юм. Ингэж ямааны мах царцамтгай чанартайн дээр хүмүүс түүнийг царцаагүй дээр нь идэх нь зүйтэйг сануулсан хэрэг юм.

ямааны сүүл мянгаас, хонины сүүл нэг нь дээр- юмны чанар чухал¹²- Монгол хониний онцлог нь өөхлөгийн давхарга ихтэй сүүлтэй, харин Монголчуудын сэтгэлгээнд сүүл нь дээрхээр буудаг байхад ямааны сүүл өөхөн бус махан давхарга илүү байдаг. Түүнчлэн Монголчууд шим тэжээл, тарга тэвээрийг өөхөөр төлөөлүүлэн ойлгодог байхад ямаанд энэ чанар бага тул өөх тос их хониний нэг сүүл илүүг гаргасан зэрэг байгаа юм.

Үүнээс үзэхэд тогтвортой хэллэгт ямаа нь жишиг хэмжүүр болж орохдоо түүний биологийн шинж чанар, зан авирыг ихээхэн тусгаж авдаг нь дээрхи жишээлэн авсан цөөхөн хэдэн үгээс илэрч байна. Ийнхүү ямааг үзэхдээ Монголчууд түүнийг хамгийн ойроор нь хоньтой буюу түүний зан авир, шинж чанартай харьцуулж үздэг

10. Ганбат, Д, Мандах, Б, нар, 2015. Бог малын ердийн хээлтүүлгийн тохироог оновчтой болгох асуудалд. ХАА-н шинжлэх ухаан сэтгүүл. Volume XIV, 61-64

11. Аким, дурд. зохиол, 63

12. Ням-Осор, Н., Өлзийсүрэн, Б., 2011. Монгол хэлний зүйр цэцэн үгийн товч тайлбар толь, УБ., 642

нь хэлцүүдээс харагдаж байна. Дээрхээс дүгнэн үзэхэд тогтвортой хэллэгт орж жишиг хэмжүүр болсон ямаа, ишиг, ухна, гэх зэрэг үгс нь Монгол хэлний тогтвортой хэллэгт юмсын хэмжээнд бага, жижгийн хэмжүүр; түргэн; ухаан муу гэсэн ерөнхий 3 утгыг илэрхийлж буй болно.


Жижигхэн, хамгийн бага, өчүүхэн, багийн хэмжүүр гэсэн нийтлэг санааг илтгэж байна.

Юмсын багийн хэмжүүр болж буйн илрэл нь ишгэн шийр ч үгүй, өнчин ишиг ч дутаахгүй зэрэг ишиг хэмээх ямааны нэг настай төлөөр илэрхийлсэн үгс нь мал сүргийн дундах 5 хошуу малаас хамгийн бага золиос, адгын бага нэгж болгож илэрхийлж байна. Түүнчлэн ямаа гэхээр тэмээ гэх зэрэг үг нь таван хошуу малын доторх хамгийн жижиг биетэй нь ямаа тул түүний шинжээр нь бага, жижгийн хэмжүүр болгосон бололтой. Үүнийг Монгол ямаа нь таван хошуу малын бусад дөрвөн амьтнаасаа бие жижиг, шөрмөс,

шандас сайтай, чийрэг зэргээр батлах юм.

Ардын билэг зүй “Монгол Гэсэрийн туужид” ...хар ямаатай орхив. Тэр ямааны сүү нэг аяга, тэр сүүнээс нэг шанага тос...¹³, Цоохор ямааг цоохор ишигтэй¹⁴, “Монголын нууц товчооны” 151-р зүйлд Ван хан 5 ямаа шөрөглөн сааж¹⁵, 152-р зүйлд харлаг ишгэн дах өмсөж¹⁶, 195-р зүйлд ишигний год ч үлдээхгүй (ийш тийш хувааж эзэлнэ)¹⁷, “Аргил цагаан өвгөн туульд” Чи гэх албатгүй, Ча гэх малгүй¹⁸ гэх мэтээр гардаг нь хамгийн бага, өчүүхэн, хямдхан эд хөрөнгө нь эдгээр юм гэсэн санааг илэрхийлдэг байна.

Мал аж ахуй, таван хошуу малыг Монголчууд зүүн гартаа багтаан дүрслэж түүний бэлчээр, 5 хошуу малын тоо, бүтэц зэргийг илэрхийлдэг уламжлалт арга байдаг. Харин ямаа нь гарын чигчий хуруунд төлөөлөгдөх бөгөөд Монголчуудын сэтгэлгээнд чигчий хуруу нь хамгийн бага, өчүүхэн, хүч сул утгыг илэрхийлдэг¹⁹.



Зураг-1 Мал аж ахуйг гараар төлөөлүүлэх арга

13. Дамдинсүрэн. Ц., 2008. Монгол Гэсэрийн тууж, УБ., 181
14. Монгол гэсэрийн тууж, дүрд.зохиол, 24
15. Дамдинсүрэн. Ц., 1990. Монголын нууц товчоо, УБ., 112
16. МНТ, 112
17. МНТ, 160
18. Нарантуяа. Р., 1985. Аргил цагаан өвгөн, УБ., 10
19. Монгол малын шинжийн судар, дүрд.зохиол, 95-101

Түргэн чанартай, хурдан, түр зуурын хэмээх утга илэрхийлэх нь ямааны хурдан шаламгай хөдөлгөөнтэйгээс хамааралтай байж болох бөгөөд ямаан омогтой, ямаан зантай зэрэг үгсээр илэрч байна. Энэ нь Хорчин бөөгийн ёсонд бөөгийн тахилгад ямааны махаар дээж тавьдаг бөгөөд бусад Монгол угсаатны ихэнхид ямааны махаар дээж талбих нь үгүй атал ямааны мах, идээ ундаа нь дээд тэнгэр буюу өргөлийн эздэд түргэн очно гэсэн утгаар тавьдаг ажээ. Энэ нь мөн ямааг буюу түүний махыг хурдан, түргэн чанараар нь үнэлж буйн хэрэг юм.

Ухаан муутай, тэнэг, зөрүүд, хоосон хөөрүү, болхи заваан буюу муу муухайгийн илрэл болж буйн жишээ элбэг бөгөөд ямаанаас янзтай, тэмээнээс гэдгэр, ямаа гэхээр тэмээ гэх, ухаанд нь ухна ишиг үхэх, халтар ухна зэргээр илэрч байна.

Түүнчлэн утга нь ардын бусад билэг зүй “Монгол гэсэрийн туужид” ...ямаан шүдэт ...чөтгөр²⁰, Онъсогот Ээрэм талын мангас, Эр эмгүй сахалтай- ямаа²¹ зэргээр илрэх нь мөн л түүнийг чөтгөр, шулам, мангастай холбож муу муухайгаар үзэж буйн жишээ

МАЛ АЖ АХУЙ, БЭЛЧЭЭРИЙН ТУХАЙД

Дунд чулуун зэвсгийн үеэс эхлэн хүн төрөлхтөн байгаль дээрх зэрлэг амьтан, ургамлуудыг гаршуулж эхлээд²⁷ Неолитийн аж ахуйн хувьсгал гарснаар байнгын бус, тогтворгүй эх үүсвэртэй хүнс тэжээлийн анчин, түүвэрчний аргаас үйлдвэрлэх аж ахуйд шилжиж хүн төрөлхтөн газар тариалан, мал аж ахуй гэсэн хоёр үндсэн

юм.

Шашны талаас ямаанд хандах хандлагыг ардын билэг зүй “Таван хошуу малын магтаалд”

.....Догшин давуу дүртэй

Дор сүлжмэл эрхтэй

Данжин дорлиг бурханы²² хүлэг болсон²³ хэмээдэг нь уг бурхан их хатуу бурхан

бөгөөд муу муухай, зэтгэрийн тэрслүүг дарах утгаар ямаа унасан байдаг бол мөн Ар хорчин бөөгийн дуудлаганд- ...шарга ямаа хөлөглөсөн хи хи, шаваа есөн тэнгэр хи хи²⁴... гэж гардаг байна.

Монгол домог зүйд бурхан, чөтгөр хоёр өрсөлдөж юмс бүтээсэн тухай өгүүлдэг бөгөөд бурхан номхон, дөлгөөн, ашиг шимтэй хонь гэгч амьтныг бүтээсэн бөгөөд чөтгөр түүнийг үзээд түүнээс илүү сэргэлэн, адтай уул хадаар дамжиж, өвсний сорыг иддэг ямааг бүтээсэн²⁵ байна. Үүнээс чөтгөрийн бүтээсэн нь хүйтэн хошуутай, бурхных нь халуун хошуутай мал болсон тухай өгүүлдэг. Түүнчлэн ямааг хаднаас бий болсон²⁶ гэсэн домог ч байдаг.

аж ахуйд орсон²⁸. Тэгвэл мал аж ахуй нь газар орны байгаль, цаг уурын нөхцөл байдал зэргээс үүдээд нэг хэсэг нь суурин буюу баарин мал аж ахуй, нөгөө хэсэг нь нүүдлийн мал аж ахуйг эрхлэх болж хоёр өөр хэлбэрт шилжсэн байна.

Нүүдлийн мал аж ахуйн нэр томъёо

1945 онд Дэлхийн Хүнс Хөдөө Аж

20. Монгол гэсэрийн тууж, дүрд, зохиол, 29

21. Гаадамба, Ш. Цэрэнсодном, Д., Монгол ардын аман зохиолын дээж бичиг, УБ., 1978, 34

22. Монгол дархчуудын шүтээн нь баруун гартаа алх, зүүн гартаа хөөрөг барьж ямаа унасан Данжин (Dancan rdorje legspe) бурхан бөгөөд энэ нь гал усыг харшуулан эгц шовх орой бүхий хадан уул дамжин явж байгаагаар дүрслэгдсэн байдаг. Энэ бурхныг зөвхөн дархан хүн шүтдэг бөгөөд ихэд хатуу бурхан гэж үздэг.

23. Монгол ардын аман зохиолын дээж бичиг, дүрд зохиол, 130-131

24. ...аман зохиолын дээж бичиг, 112

25. Дулам. С., Монгол соёл иргэнийн утга тайлал, УБ., 2013, 229

26. Мөн тэнд, 229-231

27. Содной. Ш., 2009. Монгол малын экологи, УБ., 102

28. Kottak. C.P., 2008. Cultural anthropology, New York, 152



Ахуйн байгууллага байгуулагдаж мал аж ахуйг нүүдлийн ба баарин гэсэн хоёр ангилалд хуваасан бөгөөд Оросын эрдэмтэн Б.В.Анрианов ХХ зууны эхэн үеийн байдлаар авч үзэн Төв болон Дундад Ази, Ойрхи дорнод, Умард Африк зэргийн бүс нутаг нь нүүдлийн болон хагас нүүдлийн мал аж ахуйг эрхлэх бүс²⁹ хэмээсэн бөгөөд тэдгээр нь 60-аад улс орон, нутаг байдаг³⁰ ажээ. Тэгвэл НМАА, нүүдэлчид гэдгийг “Малд тохирох аятай ус бэлчээрийг эрэлхийлэн ахуйн хэрэгцээний эрхээр малаа дагаж нэг газраас нөгөөд шилжин явагч ард түмнийг нүүдэлчид гэх буюу нүүдлийн мал аж ахуй эрхлэгчид”³¹ хэмээн Д.Төмөртогоо үзжээ.

Харин Ж.Төмөржав бэлчээрийн, Н.Эрдэнэцогт нүүдлийн мал аж ахуй гэсэн нэр томъёог ашигласан³² бөгөөд хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэд илүүтэй Ж.Төмөржавын, бусад салбарын эрдэмтэд Н.Эрдэнэцогтын саналыг дэмждэг байна. Харин энэ тухайд Н.Эрдэнэцогтын саналыг дэмжиж нүүдлийн мал аж ахуй хэмээх нэр томъёог ашиглаж байна.

Бэлчээрийн тухай

НМАА оршин тогтнох амин сүнс бол бэлчээр бөгөөд Монголын нийт нутгийн 80% нь байгалийн бэлчээр бөгөөд эрдэмтдийн үзсэнээр бэлчээрийн нийт эдэлбэрийн 5% нь өндөр уул, 6.4% нь уулын ой, 64.5% нь хээр, 19.3% нь цөл, 4.9% нь уст буюу нуга зэрэг эзэлдэг байна. Бэлчээрийн үндсэн бүс нутаг хээрийн бэлчээрийн 32% нь хуурай хээр, 29% нь цөлийн хээр эзэлдэг бол цөлийн бэлчээрийн 45% нь жинхэнэ цөл³³ байна. Үүнээс үзэхэд Монгол орон өргөн уудам бэлчээртэй мэт боловч өндөр ашиг

шимт жинхэнэ бэлчээрийн талбай багийн дээр жил ирэх тусам аж үйлдвэржилт, хотжилт, газар тариалан зэргийн болон байгалийн шалтгаанаар бэлчээрийн талбай улам хорогдсоор байна.

Бэлчээрийн даац

Бэлчээрийг зүй зохистойгоор ашиглахад бэлчээрийн даац хэмээх ойлголт байх бөгөөд энэ нь экологийн ба эдийн засгийн гэж 2 төрөл байдаг. Экологийн даац нь бэлчээрийн нэгж талбайд тодорхой хугацаанд барьж болох мал, өвсөн идэшт амьтны тоогоор илэрхийлэгддэг. Бэлчээрийн даац нь ургамлын төрөл, ургац, цаг уурын нөлөө зэргээс хамаарах тогтмол бус ойлголт юм. Монгол орны бэлчээрийн даацыг тодорхойлоход өнтэй жилд 83 сая орчим, гантай, тааламжгүй жилд 57 сая орчим хонин толгой мал барих экологийн нөөцтэй³⁴ ажээ.

Бэлчээрийн зүй зохистой бус ашиглалтаас үүдэх доройтол нь бэлчээрийн экосистемийн аль нэг хэсэгт бүтээмж буурах, зүйлийн бүрэлдэхүүн ядуурах, хөрсөнд буй болсон сөрөг өөрчлөлтөөр илэрхийлэгддэг.

Бэлчээрийн асуудал нь бэлчээр ашиглалт, малын тоо толгой, бүтэц, даац-ашиглалт, хэтрэлт, газар тариалан, хот суурин, хүний үйл ажиллагаа, цаг уурын нөлөө зэрэгтэй холбоотой бөгөөд түүнээс сэргийлэх нэг үндсэн арга нь бэлчээрийн даацад тохирсон малыг нэгж талбайд адгуулснаар нэгж талбай дахь ургамлын нөөцийн 50-иас доошгүй хувийг хөрсөн дээр үлдээхээр тооцох юм³⁵. Гэтэл малын сүргийн бүтэц, тоо толгойн зохицуулалт алдагдаж бэлчээр доройтоход хүргэж буй хүчин зүйлсийн

29. Мягмаржав, Б., 2011. Умард Африкийн нүүдлийн мал аж ахуй-дэлхийн зах зээлд, УБ., 18

30. Монгол малын экологи, дурд.зохиол, 145

31. Умард Африкийн нүүдлийн мал аж ахуй, дурд.зохиол, 19

32. Шагдарсүрэн, О., 2005. Монгол бэлчээрийн малын биологи ба нүүдлийн мал аж ахуйн онцлог, УБ., 84

33. Цэрэндаш, Ш., 2006. Бэлчээр ашиглах онолын үндэс, УБ., 8

34. Мөн тэнд 42

35. Мягмаржав, Б., (нар), 2012. Дэлхийн бэлчээрийн мал аж ахуй олон улсын аялал жуулчлалын зах зээлд, УБ., 403

нэгийг ямаатай холбон үзвэл ямаа нь 1990 он хүртэл 3 хонинд 1 ямаа оногдохоор зохицуулагдаж ирсэн бол өнөөдөр 1 хонинд 1 ямаа оногдож байна. Ямаа ихсэх нь яагаад бэлчээрт аюултайг дурдвал:

1. Мал бэлчээрлэхдээ өвс ургамлыг тодорхой хүчээр дарж гишгэлж, хөрсний механик бүтэц, бүрэлдэхүүнийг эвддэг байна. Бог малын нэгж талбайд үйлчлэх хүч зарим бодоос илүү байдаг бөгөөд тэмээ 1 см квадратад 0.44 кг тэнцэхүйц даралт учруулж байхад 30 гаруй кг жинтэй ямаа тэмээнээс 2-3 дахин илүү даралт үзүүлдэг³⁶.

2. Ямаа идээшлэхдээ өвс, ургамлыг үндсээр нь зулгааж идэхийн дээр ургамлын үржлийн ба ургал эрхтэнг сорчлон иддэг тул бэлчээрийн дахин сэргэлтэнд хэт сөрөг нөлөөтэй юм.

Монгол орны олонхи сум, багуудад бэлчээрийн даац хэтэрсэн гэсэн дүгнэлт гарсан бол ямаан сүрэг харьцангуй бага газруудад буюу ялангуяа Монгол орны зүүн бие, говийн зарим нутаг зэргээр бэлчээрийн даац хэвийн болоод харьцангуй бага алдагдсан байна.

Хүснэгт 1. Бэлчээрийн газрын байдал³⁷

Байдал	Талбай (сая га)	хувь
Эрчимтэй доройтсон бэлчээр	10.6	8.2%
Дунд зэрэг доройтсон бэлчээр	36.9	28.6%
Бага зэрэг доройтож байгаа бэлчээр	53.5	41.5%
Сайн бэлчээр	27.9	21.7%

Газар орны онцлог нөхцлөөс хамаарч аливаа малыг³⁸ тэжээхэд тохиромжтой бүс нутаг гэж бэлчээрийн газар зүйд байдаг³⁹ бөгөөд Монгол орны Алтай-Хаххөхийн уулт хээрийн бүсд 50% нь ямаа, 20% нь хонь, 20% нь тэмээ, Өмнөговийн мужид бог мал-50%⁴⁰ байж түүний ихэнхи нь ямаа байхад зохимжтой ажээ. Гэтэл одоогийн байдлаар ямаан сүргийн ихэнхи хэсэг нь өөрийн экологийн зохистой бус бүс нутгуудад илүүтэй тархсан байна.

Монголын мал сүргийн бүтэц, ямааны тоо

Мал сүргийн бүтэц Монголд эртнээс нааш ямар байсныг тоймлон авч үзвэл:

1. Дотоод Ази дахь анхны төрт улс

Хүннү гүрний үеийн мал аж ахуйг нь шүүн үзвэл Хятадын түүхэн сурвалжууд дээр үндэслэн Г.Сүхбаатар “Хүннүд хамгийн их нь бог мал(хонь, ямаа) байж дараагаар нь адуу, үхэр орно”⁴¹ хэмээсэн. Харин “Түүхэн тэмдэглэл” сурвалжид “Мал агуурсанд нь голдуу хонь, үхэр, адуу буй. Хачин адгууснаас бөхт тэмээ, илжиг, луус, чихт, тахь, хулан буй”⁴² гэсэн байдаг.

Ц.Доржсүрэн, С.Лепец, Т.Хаяши нарын археологийн судалгаанаас үзэхэд Хүннүд ямаа байсан нь лавтай мэдэгдэж байна⁴³. Хүннүгийн үеийн сурвалжид ямааны тухай тусгайлан дурддаггүй боловч хоньтой цуг хамтруулж өгүүлж байсан гэж таамагладаг бөгөөд ямаа хонийг бодвол харьцангуй

36. Бэлчээр ашиглах онолын үндэс, дурд.зохиол, 85

37. Адъяасүрэн,Ц., “Монгол орны газрын доройтлыг үнэлэх нь”, Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох асуудалд, ред. Д. Дорлигсүрэн, М. Олонбаяр, УБ., 2006, 182

38. Ямаа нь -15-аас хүйтэн биш голлох температуртай, уулт хээрийн экологийн зохимжтой нутагт тохиромжтой амьтан юм.

39. Базаргүр, Д., 1998. Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй, УБ., 220

40. Мөн тэнд, 222

41. Ганбаатар. Я., 2011. Хүннүгийн түүх, соёл, УБ., 165

42. Сы ма цян., Хүннүгийн шастир, Түүхэн тэмдэглэл, орч. Батжаргал. Б., УБ., 2011, 7

43. Хүннүгийн түүх, соёл, дурд.зохиол, 162-164

цөөн байсан хэдий ч мал сүргийн дотор багагүй тоотой байсан⁴⁴ байна.

2. Нируны үеийн мал аж ахуйг Г.Сүхбаатар мөн бог (хонь, ямаа) мал тоогоороо хамаг их, дараагаар нь адуу, үхэр, тэмээ ордог байсан⁴⁵ гэж үзсэн байна.

3. Х.Пэрлээ авгайн үзсэнээр Хятаны үеийн сүргийн бүтэц мөн адуу, үхэр, бог (хонь, ямаа) мал, тэмээ байсан⁴⁶ гэж үзсэн байна.

4. Монголын эзэнт гүрний үеин Монгол нутаг дахь малын бүтэц мөн дээрхи адил бүтэцтэй байсан ч илүүтэй өсж, үржиж байсан байна. Энэ үед хонин сүргийн өсгөх бодолого барьж байсан бөгөөд 924 онд Татарын эзэн Хятадын хаанд 30 түм хонь, адуу барьж байсан, Чингисийн цэргийн

тоо, түүнийг дагаад үржигдэж морьдын тоо зэргийн үзвэл 1 саяаас доошгүй 5 эсвэл түүнээс илүү олон сая адуутай байж, харин Д.Гонгорын Халх Товчоонд бичсэнээр тухайн үед нэг адууг 6-7 хоньтой тэнцүүлж байлгах бодлоготой байсан хэмээвэл түүнээс 7-8 дахин олон хоньтой байсан⁴⁷ хэмээжээ. Үүнээс үзэхэд Монголын сүргийн бүтэцэд ямаа эртнээс нааш байсан нь гарцаагүй юм. Харин тоо толгойны хувьд хониноос ямагт давдаггүй байсан бөгөөд түүхэн сурвалжуудад ихэнхидээ хонины нэрэн доор хамт явдаг байсан байна. Харин уг байдал нь ХХ зууны эхээс алдагдаж эхэлсээр ХХ зууны төгсгөлд бүр илүүтэй алдагджээ. Энэ нь эдийн засаг, аж үйлвэрлэл зэрэгтэй ихээхэн холбоотой юм.

Хүснэгт 2. Сүрэгт эзлэх малын хувь (он, төрөл)

Он	Бүх малын хувь	Сүрэгт эзлэх хувь					Ямааны тоо
		тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	
1918	100	2.4	11.9	11.2	59.1	15.4	1.487400
1960	100	3.7	10.9	8.3	52.6	24.5	5.635000
1980	100	2.5	8.3	10.1	59.9	19.2	4.550400
1995	100					29.8	8.520700
2000	100					34	10.269800
2006	100	0.7	6.1	6.2	42.9	44.4	15.451200
2015	100	0.7	5.9	6.8	44.6	42.1	23.592900



Зураг-2 Ямааны тоо толгой, сүрэгт эзлэх хувь, 2015⁴⁸

- 44. Хүннүгийн түүх, соёл, дүрд. зохиол, 167-168
- 45. Сүхбаатар. Г., 1992. Монгол нирун улс 330-555, УБ., 80
- 46. Пэрлээ. Х., 1959. Хятан нар тэдний Монголчуудтай холбогдох нь, УБ., 20
- 47. Чингис хааны гур улсын үеийн Монголын мал аж ахуй, (ред) Далай. Ч., УБ., 2011, 12-17
- 48. Эрдэнэсан.Э., Баярмаа.А., (ред).2016. Хөдөө аж ахуйн салбар 2015, УБ., 17-19

2015 оны байдлаар сүргийн бүтэц дээрхи байдлаар байсан бол уламжлалт мал аж ахуйн сургаальд: адуу нийт мал сүргийн 20-10%, хонь- 40-60%, ямаа-8-12%, үхэр,

тэмээ-32-18% хувь байвал⁴⁹ зохимжтой ажээ. Гэтэл энэ байдал алдагдаад удаж байгаа билээ.

ДУГНЭЛТ

Неолитын үеэс Монголчууд таван хошуу малыг өөрсдийн амьдралын эх үүсвэр болгон гэршүүлж, нүүдлийн мал аж ахуй эрхлэх болсон цагаас хойш Монголчуудын хэл, сэтгэхүй түүгээр дамжаад зан заншил, ахуй амьдрал, соёл зэрэгт таван хошуу мал, энэ тохиолдолд ямаа өөрийн ул мөрөө ямарваа байдлаар үлдээсэн байна. Түүний дотроос Монголчуудын ардын билиг зүй тэр дундаа тогтвортой хэллэгт буй ямаа болон түүний хам төрлүүдийг жишиг хэмжүүр болгосон хэлцүүд нь дараах үндсэн утгуудыг илтгэж байна:

- Түргэн чанартай, хурдан, түр зуурын
- Ухаан муутай, тэнэг, зөрүүд, алдаатай, хоосон хөөрүү, болхи заваан
- Жижигхэн, хамгийн бага, өчүүхэн, багийн хэмжүүр гэсэн нийтлэг санааг илтгэнэ.

1. Үүнээс үзэхэд Монгол хэлний тогтвортой хэллэг болоод ардын билиг зүйд ямаагаар сайн, сайхан, эерэг утгыг төлөөлөх нь бага бөгөөд муу, муухай, сөрөг гэсэн утгыг ерөнхий, тойруу байдлаар дээрх утгуудаар илэрхийлдэг.

2. Харин яагаад ямааг ийнхүү буруу үзэж, мууг төлөөлүүлэх болсон нь түүний өвсийг үндсээр нь зулгааж иддэг, гишгэц, бэлчээрт сүйтгэлтэйг нь бодож Монголчууд

сүрэгт хэт олшруулахгүй байх үүднээс үлгэрлэн өөрсдийн хэл, ардын билгээрээ дамжуулан хойч үеэ сурган хүмүүжүүлж байсан гэсэн дүгнэлт хийж байна.

3. Газрыг зөвхөн тариалан эрхэлдэг, суурин иргэдэд л хамгийн чухал мэтээр ойлгодог ч НМАА эрхлэх ард түмэнд ч мөн тариаланч иргэдээс дутахааргүй чухал бөгөөд хэрэв бэлчээр-газар үгүй болбол нүүдлийн хэмээх тодотголоо алдаж, НМАА төдийгүй, нүүдлийн соёлд аюул учрах болно. Харин нүүдлийн аж ахуй, соёл нь Байгаль-Хүн-Мал гурвын харилцан шүтэлцээн дунд оршдог бөгөөд өнөөдөр энэ шүтэлцээ, тэнцвэрт байдал алдагдаж байгаль буюу бэлчээрийн хувь оролцоо багасаж, хүн, малын хувь тэнцвэргүй ихсэж байна.

4. Өнөөгийн нөхцөлд дээрх ямааг жишиг хэмжүүр болгосон тогтвортой хэллэгүүдийн сурган хүмүүжүүлэх чиг үүрэг нь мартагдаж сарнин, ямааны ноолуур зэргийн эдийн засгийн ашиг шимийг бодож ямааг хэт их болгож байна. Иймд Монголчууд ойрын жилд бэлчээрийн экологийн даацын бодлогод тулгуурлаж малын тоонд анхаарч ирсэн ч, өнөөгийн бэлчээрийн даац хэтэрч буй үед төр болон ард иргэд бэлчээрийн эдийн засгийн бодлогод тулгуурлаж, малын чанарт илүү анхаарах нь чухал гэсэн санал дэвшүүлж байна.

49. Сүхбаатар.Х., 2009. Монгол малын шинжийн судар, УБ., 56



НОМ ЗҮЙ

1. Аким. Г., 1982. Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь, УБ.
2. Батаа. Д, (нар), 2011. Бэлчээрийн Монгол мал үржүүлэх арга ухаан, УБ.
3. Бат-Ирээдүй. Ж., 2007. Монгол хэлний хэвшмэл хэллэг дэх хэлц үгийн утга. УБ.
4. Бат-Ирээдүй. Ж., 2008. Монгол хэлний хэлц үгийн сан. УБ.
5. Бат-Ирээдүй. Ж., 2009. Монгол хэлбичиг утга, соёл, хэрэглээ, УБ.
6. Бат-Ирээдүй. Ж., 2014. Монгол хэлний хэлц үг, хэллэгийн утга хэрэглээ. УБ.
7. Базаргүр. Д., 1998. Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй, УБ.
8. Баянсан.Ж., 2002. Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ., УБ.
9. Гаадамба, Ш. Цэрэнсодном, Д., 1978. Монгол ардын аман зохиолын дээж бичиг, УБ.
10. Ганбаатар. Я., 2011. Хүннүгийн түүх, соёл, УБ.
11. Ганбат. Д, Мандах.Б, нар, 2015. Бог малын ердийн хээлтүүлгийн тохироог оновчтой болгох асуудалд. ХАА-н шинжлэх ухаан сэтгүүл .Volume XIV., 61-64
12. Дамдинсүрэн. Ц., 2008. Монгол Гэсэрийн тууж, УБ.
13. Дамдинсүрэн. Ц., 1990. Монголын нууц товчоо, УБ.
14. Дулам. С., 2013. Монгол соёл иргэншлийн утга тайлал, УБ.
15. Доржготов. Д., (ред). Монгол улсын үндэсний атлас. УБ., 2009
16. Дорлигсүрэн. Д., Олонбаяр. М. (ред.) Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох асуудалд, УБ., 2006
17. Мягмаржав. Б., 2011. Умард Африкийн нүүдлийн мал аж ахуй-дэлхийн зах зээлд, УБ.
18. Мягмаржав. Б., (нар), 2012. Дэлхийн бэлчээрийн мал аж ахуй олон улсын аялал жуулчлалын зах зээлд, УБ.
19. Нарантуяа. Р., 1985. Аргил цагаан өвгөн, УБ.
20. Ням-Осор.Н., Өлзийсүрэн. Б., 2011. Монгол хэлний зүйр цэцэн үгийн товч тайлбар толь, УБ.
21. Пэрлээ. Х., 1959. Хятан нар тэдний Монголчуудтай холбогдох нь, УБ.
22. Сы ма цян., Хүннүгийн шастир, Түүхэн тэмдэглэл, орч. Батжаргал. Б., УБ., 2011
23. Содной. Ш., 2009. Монгол малын экологи, УБ.
24. Сүхбаатар. Г., 1992. Монгол нурун улс 330-555, УБ.
25. Сүхбаатар.Х., 2009. Монгол малын шинжийн судар, УБ.
26. Цэрэндаш. Ш., 2006. Бэлчээр ашиглах онолын үндэс, УБ
27. Чингис хааны гур улсын үеийн Монголын мал аж ахуй, (ред) Далай. Ч., УБ., 2011
28. Шагдарсүрэн. О., 2005. Монгол бэлчээрийн малын биологи ба нүүдлийн мал аж ахуйн онцлог, УБ.
29. Эрдэнэцогт. Н., 1998. Монголын нүүдлийн мал аж ахуй, УБ.
30. Эрдэнэсан.Э., Баярмаа.А., (ред).2016. Хөдөө аж ахуйн салбар, 2015, УБ., 17-19
31. Kottak.C.P., 2008. Cultural Anthropology. New York



FOLK PEDAGOGY EMERGED BY IDIOM

D.Munkhtamir, S.Byambadorj

*Department of Anthropology and Archeology, National University of Mongolia
E-mail: s.tamiraa11@gmail.com*

Mongolians have a pastoralism and they domesticated animals as sheep, goats, camel, cattle, horses and yak. Pastoralism (specially-goats) to affect Mongolian's custom, making a living, culture, language and others. Pastoralism based on interaction of nature-livestock-man but recently livestock's increasing, cultivation, industrialization and others are effected in regression of pasture. Mongolians are inheriting about above interaction-herding pedagogy for next generations by folk pedagogy, folklore, idioms.

Keywords: *folk pedagogy, folklore, idiom, pastoralism, pasture, goat;*